



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн

12/12

Т О Г Т О О Л

1959 оны 9 дүгээр
сарын 9-ны өдөр

Дугаар 367

Улаанбаатар
хот

Дулаацуулах байгуулалтыг хүлээж
авахтай холбогдсон зарим арга
хэмжээний тухай.

Улаанбаатар хотын дулаацуулах байгуулалтын бэлхэн болсон
хэсгийг ашиглалтад хүлээлгэн өх болсонтой холбогдуулан, Б.Н.М.
А.Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Улаанбаатар хотын дулаацуулах байгуулалтын ашиглалт, засварыг хариуцах үүрэгтэй дулааны шугам сүлжээний газрыг цахилгаан
комбинатын харьяанд аж ахуйн тооцооны үндсэн дээр байгуулсугай.

2. Аж Үйлдвэрийн Яам/н.ЛУВСАНЧОЙМБОЛ/-д даалгах нь:

а/цахилгаан комбинатаас дулаацуулах байгуулалтаар дамжуулан гаргах дулааны өөрийн өртгийг энэ оны 9 дүгээр сарын 20-ны
дотор Улсын Төлөвлөгөөний Комисст оруулан батлуулсугай;

б/дулааны шугам сүлжээний үйлчилгээнд шаардагдах мэрэгжилтэй
ажилчдыг бэлтгэх зорилгоор 45 хоногийн курсийг 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр нээж хичээллүүлсүгэй.

3. Дулаацуулах байгуулалтын ашиглалт, засварын ажлын талаар
1957 онд Зөвлөлт Холбоот Улсад дадлага хийсэн 9 хүнийг 1 дүгээр
хавсралтын ёсоор Аж Үйлдвэрийн Яамны мэдэлд шилжүүлэхийг
Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаа/н.БАТАА/, Улсын Барилгын Хороо/н.МАЙДАР/ нарт даалгасугай.

4. Улсын Төлөвлөгөөний Комисс/н.РАГЧАА/-д даалгах нь:

а/дулаацуулах байгуулалтын шугам, сүлжээний үйлчилгээнд
шаардагдах „ГАЗ-51” машин 2, „ГАЗ-69” машин нэгийг Аж Үйлдвэрийн
Яаманд шилжүүлэн өгсүгэй;

б/дулааны шугам сүлжээний үйлчилгээнд эхний үед яаралтай
хэрэглэгдэх тусгай хийцтэй машин, механизм, багаж тоноглолыг 2-р
хавсралтын ёсоор 1960 оны захиалгад нэмж оруулсугай;

в/дулаацуулах байгуулалтын ашиглалтыг хэвийн ажиллагаатай
байлгахад шаардагдах зарим материал, багажийг худалдан авахад
зориулан, дулаацуулах байгуулалтын гол шугамд зарим барилгыг холбох
зардалд энэ оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр батлагдсан

хөрөнгөнөөс 100 000 төгрөг гаргаж өгсүгэй.

5.Энэ онд дулаацуулах байгуулалтын гол шугамд холбох барилгын тоо цөөн байгааг харгалзан,уул газрын үйлдвэрлэл-санхүүгийн төлөвлөгөөг гаргуулж,түүний алдагдлыг цахилгаан комбинатын ашгаар хаахыг Сангийн Яам/н.ДҮГЭРСҮРЭН/-д даалгасугай.

6.Дулааны шугам сүлжээний газарт шаардагдах эд хогшил худалдан авах зардалд энэ оныхоо хөрөнгө оруулалтын ашиглагдаагүй хөрөнгөнөөс 37 750 төгрөг зарцуулахыг Аж Үйлдвэрийн Яам/н.ЛУВСАН - ЧОЙМБОЛ/-д зөвшөөрсүгэй.

Б.Н.М.А.Улсын Сайд нарын
Зөвлөлийн орлогч дарга

МОЛОМЖАМЦ

Б.Н.М.А.Улсын Сайд нарын
Зөвлөлийн Хэрэг эрхлэх
газрын I -р орлогч дарга.

ЦЭРЭНЖАВ

Хуулбар үнэмтгий болгон
эрхлэгч



ДАГВАДОРЖ

Бадамжавт.
Дурьдсан хөрөнгөнийг
холбогдох газруудтай харгалзан
харгалтай шингүүрээ авга
хэмнээ авх хэрэгтэй.
14